



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/66

Мөрөн сум

┌ Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн ┐
орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/590 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Батлагдсан зөвлөлийн бүрэлдэхүүн Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/590 дугаар тушаалын гуравдугаар хавсралтыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажилласугай.

3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд салбар дундын оролцоог ханган ажиллахыг "Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 02
дугаар сарын 10 ний өдрийн А/66
дугаар захирамжийн хавсралт

“Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн
орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн

Салбар зөвлөлийн орлогч дарга :Эрүүл мэндийн газрын дарга

Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга :Эрүүл мэндийн газрын нөхөн үржихүйн
эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Салбар зөвлөлийн гишүүд:

- Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэлийн ажилтан
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн удирдлагын хэлтсийн дарга
- Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
- Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
- Нэгдсэн эмнэлгийн захирал
- Боловсрол Шинжлэх ухааны газрын дарга
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
- Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Статистикийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Мөрөн сумын Засаг дарга
- Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
- Төрийн бус байгууллагын төлөөлөл /зөвшилцсөнөөр/
- Монголын сумын эмч мэргэжилтний холбооны Хөвсгөл аймаг дах салбар зөвлөлийн дарга /зөвшилцсөнөөр/